

I-III/2021


Тархаасан: 2021 оны 4 дүгээр сарын 14



Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2021 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 2.9 их наяд төгрөг, үүнээс нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж нь 2.6 их наяд төгрөг байна. Нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж нь нийт орлогын 91.4 хувийг эзэлж байна.

Зураг 1. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эхний улирлын байдлаар, тэрбум төгрөг



Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2.7 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 96.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн хэмжээ 2021 оны 3 дугаар сард 1.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 38.8 (4.0%) тэрбум

төгрөг, өмнөх оны мөн үеэс 295.8 (42.0%) тэрбум төгрөгөөр өсөж, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 983.8 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 28.0 (2.9%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 123.3 (14.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2021 оны 3 дугаар сард 16.5 тэрбум төгрөгийн ашигтай гарч, өмнөх сараас 10.8 (2.9 дахин) тэрбум төгрөг өссөн байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 83.5 хувийг татварын орлого, 7.9 хувийг татварын бус орлого, 3.9 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 4.8 хувийг тогтворжуулалтын сангийн орлого тус тус эзэлж байна.

Татварын нийт орлого 2021 оны эхний 3 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 2.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 489.0 (25.6%) тэрбум төгрөгөөр өсөхөд нийгмийн даатгалын орлого 2.8 (0.6%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч нэмэгдсэн өртгийн албан татвар 258.6 (65.8%) тэрбум төгрөг, орлогын албан татвар 104.4 (19.1%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 32.7 (18.2%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 30.8 (20.6%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Татварын нийт орлого 2021 оны 3 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 924.7 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 52.1 (6.0%) тэрбум төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 175.9 (49.3%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч нэмэгдсэн өртгийн албан татвар 71.8 (35.0%) тэрбум төгрөг,


бусад татвар, төлбөр хураамжийн орлого 46.1 (2.4 дахин) тэрбум төгрөг, онцгой албан татварын орлого 30.8 (52.1%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 30.7 (20.2%) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 27.3 (47.2%) тэрбум төгрөг, хөрөнгийн албан татварын орлого 21.3 (3.4 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт 1. Улсын нэгдсэн төсвийн орлого, жил бүрийн эхний улирлын байдлаар, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018 I-III	2019 I-III	2020 I-III	2021 I-III*	$\frac{2021^* \text{I-III}}{2020 \text{ I-III}}$ %
Нийт орлого, тусламжийн хэмжээ	1 993.8	2 433.1	2 224.6	2 876.1	129.3
Ирээдүйн өв сан	117.2	255.9	144.3	110.9	76.9
Тогтворжуулалтын сан	65.7	13.8	6.5	137.3	21.2 ¹
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн хэмжээ	1 810.9	2 163.4	2 073.8	2 627.9	126.7
Татварын орлого	1 618.1	1 971.5	1 912.6	2 401.6	125.6
Орлогын албан татвар	412.3	537.6	546.7	651.1	119.1
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	233.3	342.0	331.7	420.6	126.8
Хувь хүний орлогын албан татвар	179.8	195.7	215.3	230.5	107.1
Нийгмийн даатгалын орлого	344.4	438.9	459.5	456.7	99.4
Хөрөнгийн албан татвар	31.7	27.8	32.3	42.6	131.9
Нэмэгдсэн өртгийн албан татвар	380.9	381.6	392.8	651.3	165.8
Онцгой албан татвар	164.6	213.5	179.5	212.2	118.2
Тусгай зориулалтын орлого	2.6	4.1	3.4	3.3	96.4
Гадаад үйл ажиллагааны орлого	124.7	154.4	148.7	203.8	137.1
Бусад татвар, төлбөр, хураамж	157.0	213.7	149.7	180.5	120.6
Татварын бус орлого	192.8	191.9	161.2	226.3	140.3
Нийтлэг татварын бус орлого	191.9	186.2	156.9	209.2	133.3
Хөрөнгийн орлого	0.1	0.2	0.2	0.3	186.2
Тусламжийн орлого	0.7	5.6	4.2	16.8	4.0 ¹

¹ Дахин их

Зураг 2. Улсын нэгдсэн төсвийн татварын орлогын бүтэц, дүнд эзлэх хувиар




Татварын орлогод 2021 оны эхний улирлын байдлаар орлогын албан татвар 27.1 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 27.1 хувь, нийгмийн даатгалын орлого 19.0 хувь, бусад татвар 9.5 хувь, онцгой албан татвар 8.8 хувь, гадаад

үйл ажиллагааны орлого 8.5 хувийг тус тус эзэлж байна.

Татварын нийт орлогод нэмэгдсэн өртгийн албан татварын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 6.6 пункт, гадаад үйл ажиллагааны орлогынх 0.7 пунктээр өсөж, нийгмийн даатгалын орлогын эзлэх хувь 5.0 пункт, орлогын албан татварынх 1.5 пункт, онцгой албан татварынх 0.6 пункт, бусад татварынх 0.3 пунктээр тус тус буурсан байна.

Зураг 3. Улсын нэгдсэн төсвийн татварын болон татварын бус орлого, нийт зарлага, цэвэр зээл, жил бүрийн эхний улирлын байдлаар, тэрбум төгрөг



Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2021 оны эхний улирлын байдлаар 2.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 374.3 (15.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Зарлагын өсөлтөд урсгал зардал өмнөх

оны мөн үеэс 268.4 (12.6%) тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 61.5 (25.5%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.


Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2021 оны 3 дугаар сард 983.8 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 28.0 (2.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Улсын нэгдсэн төсвийн зарлага, цэвэр зээл, жил бүрийн эхний улирлын байдлаар, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018 I-III	2019 I-III	2020 I-III	2021 I-III*	2021*I-III / 2020 I-III
Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ	1 836.6	1 969.1	2 349.8	2 724.1	115.9
Нийт зарлага	1 830.7	1 968.5	2 373.5	2 703.4	113.9
Урсгал зардал	1 620.6	1 800.5	2 132.6	2 401.0	112.6
Бараа, ажил үйлчилгээний зардал	693.7	826.5	964.5	880.6	91.3
Хүү	230.1	171.1	185.3	132.4	71.4
Татаас	75.9	52.1	88.5	79.0	89.3
Урсгал шилжүүлэг	620.9	750.8	894.3	1 309.0	146.4
Засгийн газрын урсгал шилжүүлэг	3.9	15.1	29.2	127.7	4.4 ¹
Бусад урсгал шилжүүлэг	617.0	735.7	865.0	1 181.3	136.6
Хөрөнгийн зардал	210.0	168.0	240.9	302.4	125.5
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	5.9	0.6	- 23.7	20.7	-
Эргэж төлөгдөх цэвэр зээл	- 3.2	- 6.0	- 31.2	4.2	-
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	9.1	6.5	7.5	16.5	2.2 ¹

¹ Дахин их

Зураг 4. Улсын нэгдсэн төсвийн урсгал зардлын бүтэц, дүнд эзлэх хувиар



Урсгал зардалд урсгал шилжүүлэг 54.5 хувь, бараа үйлчилгээний зардал 36.7 хувь, хүүгийн зардал 5.5 хувь, татаас 3.3 хувийг эзэлж байна.

Хөрөнгийн зардалд 2021 оны эхний улирлын байдлаар 302.4 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 61.5 (25.5%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Хөрөнгийн зардалд 2021 оны 3 дугаар сард 91.0 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх сараас 26.7 (22.7%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Хөрөнгийн зардалд өсөхөд бусад хөрөнгийн зардал 29.8 (61.9 %) тэрбум төгрөг, их засварын зардал 4.2 (33.7%) тэрбум төгрөг, стратегийн нөөц хөрөнгийн зардал 1.7 (19.3%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч барилга, байгууламжийн зардал 57.9 (35.3%) тэрбум төгрөг, тоног төхөөрөмжийн зардал 39.3 (6.3 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Хөрөнгийн зардалд барилга байгууламжийн зардал 73.4 хувь, тоног төхөөрөмжийн зардал 15.4 хувь, бусад хөрөнгийн зардал 6.1 хувь, их засварын зардал 2.7 хувь, стратегийн нөөц хөрөнгийн зардал 2.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс тоног төхөөрөмжийн зардлын эзлэх хувь 12.3 пункт, барилга байгууламжийн зардлынх 5.3 пунктээр өсөж, харин бусад хөрөнгийн зардлын эзлэх хувь 13.9 пункт, их засварын зардлынх 2.5 пункт, стратегийн нөөц хөрөнгийн зардлынх 1.3 пунктээр тус тус буурчээ.

Орон нутгийн төсөв


Орон нутгийн төсвийн орлого 2021 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 830.0 тэрбум төгрөг, зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл 560.6 тэрбум төгрөг болж, орон нутгийн тэнцвэржүүлсэн тэнцэл 269.4 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Орон нутгийн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ашиг өмнөх оны мөн үеэс 85.6 (46.6%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Орон нутгийн төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 42.8 (5.4%)

тэрбум төгрөгөөр өсөхөд татварын орлого 59.9 (20.4%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Зураг 5. Орон нутгийн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эхний улирлын байдлаар , тэрбум төгрөг



Орон нутгийн төсвийн орлого, тусламжийн хэмжээ 2021 оны 3 дугаар сард 342.1 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 84.1 (32.6%) тэрбум төгрөгөөр төгрөгөөр өсөж, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 217.6 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 13.3 (6.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Даатгалын сан

Нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны эхний 3 сарын байдлаар 643.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 48.1 (8.1%) тэрбум төгрөг, нийт зарлага 628.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 51.2 (8.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого өсөхөд тусламжийн орлого 48.9 (31.5%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт 3. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, жил бүрийн эхний улирлын байдлаар, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018 I-III	2019 I-III	2020 I-III	2021 I-III*	<u>2021*I- III</u> 2020 I-III
Нийт орлого	472.3	552.1	595.5	643.6	108.1
Нийгмийн даатгалын сангийн орлого	317.2	400.8	440.6	439.8	99.8
Тусламжийн орлого	155.1	151.4	154.9	203.8	131.5
Нийт зарлага	434.2	493.5	577.1	628.3	108.9
Бараа үйлчилгээний зардал	4.3	5.9	6.1	6.0	98.1
Урсгал шилжүүлэг	429.9	487.6	571.0	622.5	109.0
Эргэж төлөгдөх төлбөрийн хассан цэвэр зээл	-	-	-	-180.9	-
Тэнцэл	38.1	58.6	18.4	15.3	83.2

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2021 оны эхний улирлын байдлаар 217.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 111.5 (2.1 дахин) тэрбум төгрөг, нийт зарлага 189.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 101.4 (2.2 дахин) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага, жил бүрийн эхний улирлын байдлаар, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018 I-III	2019 I-III	2020 I-III	2021 I-III*	<u>2021*I- III</u> 2020 I-III	%
Нийт орлого	69.2	113.6	105.7	217.1	2.1¹	
ЭМД-ын хураамжийн шимтгэл	69.2	113.6	105.7	217.1	2.1 ¹	
Нийт зарлага	68.3	72.3	88.1	189.5	2.2¹	
Бараа үйлчилгээний зардал	0.5	0.7	0.7	2.2	3.2 ¹	
Татаас	20.6	5.9	7.1	11.2	158.0	
Урсгал шилжүүлэг	47.2	65.7	80.3	176.2	2.2 ¹	
Эргэж төлөгдөх төлбөрийн хассан цэвэр зээл	-	-	-	-180.0	-	
Тэнцэл	0.8	41.3	17.6	27.7	157.3	

¹ Дахин их

Ойлголт, тодорхойлолт:

Монгол Улсын нэгдсэн төсөв: Улсын төсөв, орон нутгийн төсөв, хүний хөгжил сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого: Татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Төсвийн орлого: Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Улсын төсөв: Улсын Их Хурал (УИХ)-аас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн тэнцэл: Тэнцвэржүүлсэн орлогоос нийт зарлага, цэвэр зээлийг хасаж тодорхойлно.

Эх үүсвэр: Сангийн яам

Ангилал, код: Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилал

Тайлбар:

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 5 дугаар сарын 17

Хавсралт:

*Эдийн засгийн статистикийн газрын
Статистикч Ч.Мөнхтуул
Утас (976-51)-261565*

*Эдийн засгийн статистикийн газрын
дарга Э.Эрдэнэсан
Утас (976-51)-266414*

